



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МӨНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,
<http://www.mjia.gov.mn>

2017.09.22 № 1-1 / 3565
танай 2017.09.14 -ны № 17 / 165 -Т

Хүсэлт уламжлах тухай

Тус яаманд “Өргөн тээвэрлэх машин төхөөрөмж” үндэсний холбоо ТББ-аас албан бичиг ирүүлсэн байна.

Тус албан бичигт Монгол Улсад өргөх төхөөрөмж /кран, лифт, барилгын өргүүрүүд/-ийн ашиглалтын аюулгүй байдлыг Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2008-2011 онд баталсан 7 дүрмээр зохицуулдаг. Гэвч эдгээр дүрэмд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Барилгын тухай хуулиас давсан зохицуулалтыг тусгаснаас гадна уг дүрэм хүчинтэй байгаа эсэх нь тодорхойгүй талаар дурдаад, холбогдох тайлбарыг хийж, хууль зүйн зөрчлийг арилгуулах талаар дэмжлэг хүссэн байна.

Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “өргөх байгууламж” гэж босоо болон хэвтээ чиглэлд хүн, ачаа өргөх, тээвэрлэх зориулалт бүхий суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг хэлнэ”, мөн хуулийн 33 дугаар зүйлд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг заасан бөгөөд мөн зүйлийн 33.1.15-д “барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам батлах,”-аар тус тус заасан байна.

Түүнчлэн Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг нэгдүгээр, “Эскалаторыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг хоёрдугаар, мөн сайдын 2010 оны 234 дүгээр тушаалаар “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг гуравдугаар, “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг дөрөвдүгээр, мөн сайдын 2011 оны 211 дүгээр тушаалаар “Манипуляторт краныг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг хавсралтаар, мөн сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар “Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батлахдаа тухайн үед мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Харин хавсралтад заасан “Зорчигчийн ган татлагат дүүжин болон чирэх замыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийг баталсан байгууллага тодорхойгүй, огноо, дугаарыг бичээгүй байх тул хүчинтэй болон улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эсэх талаар лавлагаа, мэдээлэл өгөх боломжгүй байна.